

**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ДААТГАЛЫН ГАЗАР**

**ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГУУДЫН 2010 ОНЫ
3 ДУГААР УЛИРЛЫН САНХҮҮ, ДААТГАЛЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТАНИЛЦУУЛГА**

ТАНИЛЦСАН:

ХОРООНЫ ДАРГА
ХОРООНЫ ГИШҮҮН
ХОРООНЫ ГИШҮҮН
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

Д. БАЯРСАЙХАН
Б. ШАРАВСАМБУУ
Д. ДҮГЭРЖАВ
Х. БУМ-ЭРДЭНЭ

ХЯНАСАН:

ДААТГАЛЫН ГАЗРЫН ДАРГА
ДААТГАЛЫН ГАЗРЫН ОРЛОГЧ ДАРГА

С. ГАНБОЛД
П. ЦЭРЭНДЭЖИД

БОЛОВСРУУЛСАН:

ДААТГАЛЫН ГАЗРЫН ХЯНАН ШАЛГАГЧ

Э. ЭРДЭНЭТУЯА

УЛААНБААТАР ХОТ
2010.10.28

ГАРЧИГ

I.	ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	3
II.	ДААТГАГЧИЙН ХӨРӨНГӨ,	4
III.	ДААТГАГЧИЙН ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ	6
IV.	ДААТГАГЧИЙН ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ОРЛОГО	8
V.	ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР	11
VI.	НӨХӨН ОЛГОВРЫН ТҮВШИН	13
VII.	ДАВХАР ДААТГАЛ	14
VIII.	ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧ	15
IX.	ДААТГАЛЫН ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧ	15
X.	ДҮГНЭЛТ	15

ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГУУДЫН 2010 ОНЫ 3 ДУГААР УЛИРЛЫН САНХҮҮ, ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТАНИЛЦУУЛГА

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

2010 оны 3 дугаар улирлын байдлаар даатгалын зах зээл дээр 16 даатгалын компани, 136 даатгалын компанийн салбар, 1998 даатгалын төлөөлөгч, 8 даатгалын зуучлагч компани, 6 даатгалын хохирол үнэлэгч компани, 10 актуарч, нийт 2174 тусгай зөвшөөрөл эзэмшигчид үйл ажиллагаагаа явуулсан байна.

Хүснэгт-1

Даатгалын зах зээл дээрх тусгай
зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх эзэмшигчид, тоогоор

№		2008-III	2009-III	2010-III
1	Даатгагч	16	17	16
2	Даатгалын компанийн салбар	109	130	136
3	Даатгалын төлөөлөгч	940	1639	1998
4	Даатгалын зуучлагч	4	4	8
5	Даатгалын хохирол үнэлэгч			6
6	Даатгалын актуарч			10
	Бүгд	1069	1790	2174

Энэ оны 3 дугаар улирлыг өмнөх 2008, 2009 оны 3 дугаар улиралтай харьцуулбал даатгалын зах зээл дээрх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тоо 1.2 дахин өссөн үзүүлэлттэй байгаа бөгөөд үүний дийлэнх хувийг даатгалын төлөөлөгчдийн тооны өсөлт эзэлж байна.

Мөн энэ оны эхний 3 улирлын байдлаар шинээр даатгалын зуучлагч 4, даатгалын хохирол үнэлэгч 6, нийтдээ 10 тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд нэмэгдсэн.


Доорх графикаас харахад дотоодын даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулахаар тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээд, хувь хүмүүсийн тоо 2008 оноос 2009 оны хооронд 1.7 дахин өсөлттэй, 2009 оноос 2010 оны хооронд 1.2 дахин өсөлттэй байгаа нь энэхүү зах зээл хурдацтай хөгжиж байгааг илтгэж байна (График-1).



II. ДААТГАГЧИЙН ХӨРӨНГӨ

Энэ оны 3 дугаар улиралд даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй 16 даатгалын компанийн хөрөнгийн нийт хэмжээ 46.0 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.8 тэрбум төгрөгөөр буюу 1.2 дахин өссөн ба 2008 оны мөн үетэй харьцуулахад 11 тэрбум төгрөгөөр буюу 1.3 дахин өссөн байна. График-2

Даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ, тэрбум төгрөгөөр



2008 оны 3 дугаар улиралд системийн дүнгээр нийт эргэлтийн хөрөнгө 30.3 тэрбум төгрөг буюу нийт хөрөнгийн 86.6 хувь, эргэлтийн бус хөрөнгө нь 4.7 тэрбум төгрөг буюу нийт хөрөнгийн 13.4 хувийг эзэлж байсан бол 2009 оны 3 дугаар улиралд эргэлтийн хөрөнгө 34.7 тэрбум төгрөгт хүрч нийт хөрөнгийн 88.5 хувийг эзэлж, 2010 оны эргэлтийн хөрөнгө 41.3 тэрбум төгрөг буюу нийт хөрөнгийн 89.7 хувийг эзэлж өмнөх оны мөн үеийнхээс 1.2 пунктээр өсч эргэлтийн хөрөнгө 6.6 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Эргэлтийн бус хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад өссөн үзүүлэлттэй байна.

Эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгө

Хүснэгт-2

(сая төг)

Үзүүлэлтүүд	2008-III		2009-III		2010-III		өсөлт/бууралт	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	пункт
Эргэлтийн хөрөнгө	30308.9	86.6	34696.3	88.5	41298.1	89.7	6 601.8	1.2
Эргэлтийн бус хөрөнгө	4728.0	13.4	4511.6	11.5	4735.9	10.3	224.3	-1.2
Нийт хөрөнгө	35036.9	100.0	39207.9	100.0	46034.0	100.0	6826.1	

2010 оны 3 дугаар улирлын байдлаар эргэлтийн хөрөнгийн 63.7 хувийг мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө, 23.2 хувийг богино хугацаат хөрөнгө оруулалт, 9.8 хувийг дансны авлага, үлдэх 3.3 хувийг бусад эргэлтийн хөрөнгө эзэлж байна. Эргэлтийн хөрөнгийн бүтцийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө 12.2 пунктээр буурч, дансны авлага 3.0 пунктээр, богино хугацаат хөрөнгө оруулалт 13.2 пунктээр тус тус өсч, бусад эргэлтийн хөрөнгө 3.9 пунктээр тус тус буурсан байна.

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн нийт эргэлтийн хөрөнгөнд эзлэх хувь хэмжээ 2009 оны мөн үеийнхээс 11.5 пунктээр буурсан, харин богино хугацаат хөрөнгө оруулалтын хувь хэмжээ өмнөх оноос 13.2 пунктээр өссөн байна. Энэ нь 2008 оны 3 дугаар улирлаас эхлэн Хорооны 2006 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгагчийн дүрмийн сан болон нөөц сангаас хөрөнгө оруулалт хийхэд тавигдах шаардлага” журмын дагуу хийгдэж буй хяналтын нөлөөлөл юм.

Хүснэгт-3

Эргэлтийн хөрөнгө

(сая төг)

Үзүүлэлтүүд	2008-III		2009-III		2010-III		өсөлт/бууралт	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	18170.8	60.0	26350.7	75.9	26296.9	63.7	-53.8	-12.2
Богино хугацаат хөрөнгө оруулалт	6519.3	21.5	3480.8	10.0	9598.8	23.2	6118.0	13.2
Дансны авлага	2311.6	7.6	2369.5	6.8	4058.9	9.8	1689.4	3.0
Бусад эргэлтийн хөрөнгө	3307.2	10.9	2495.3	7.2	1343.5	3.3	-1151.8	-3.9
Эргэлтийн хөрөнгийн дүн	30308.9	100.0	34696.3	100.0	41298.1	100.0	6601.8	

2010 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй компаниудыг хөрөнгийн хэмжээгээр нь жагсаахад “Монгол даатгал” ХХК 13.6 тэрбум төгрөгийн хөрөнгөтэйгээр даатгалын зах зээл дэх нийт хөрөнгийн 29.7 хувийг эзэлж байгаа бол “Жонон даатгал” ХХК хамгийн бага буюу 0.9 тэрбум төгрөгийн хөрөнгөтэйгээр зах зээлийн нийт хөрөнгийн 2.0 хувийг эзэлж байна (Хүснэгт-3).

Даатгалын зах зээл дэх нийт хөрөнгийн 61.7 хувийг 5 даатгалын компани (“Монгол даатгал”, “Бодь даатгал”, Тэнгэр даатгал ХХК “МИГ даатгал” ХХК, Ард даатгал ХХК) –ийн хөрөнгө бүрдүүлж байна.

Нийт хөрөнгийн хэмжээ

Хүснэгт-4


№	Компанийн нэр	Нийт хөрөнгө (сая.төг)	Эзлэх хувь
1	Монгол даатгал	13 654.3	29.7
2	Бодь даатгал	4 311.8	9.4
3	Миг даатгал	3 756.1	8.2

4	Тэнгэр даатгал /Прайм/	4 235.5	9.2
5	Ард даатгал	2 395.1	5.2
6	Номин даатгал	2 924.7	6.4
7	Түшиг даатгал	2 359.4	5.1
8	Практикал даатгал	2 763.3	6.0
9	Нэйшнл лайф даатгал	1 106.3	2.4
10	Улаанбаатар хотын даатгал	1 317.7	2.9
11	УБ даатгал	1 295.6	2.8
12	Монгол траст Холдинг даатгал	1 178.8	2.6
13	Ган зам даатгал	1 525.6	3.3
14	Жонон даатгал	906.8	2.0
15	Мөнх даатгал	1 072.0	2.3
16	Гранд даатгал	1 231.0	2.7
	СИСТЕМИЙН НИЙТ ДҮН	46 034.0	100.0

II. ДААТГАГЧИЙН ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ

Даатгалын компаниудын нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмчид даатгалын нөөц сан, эзэмшигчдийн өмч, өр төлбөрийн эзлэх хувь хэмжээг сүүлийн 3 жилийн 3 дугаар улирлын байдлаар харьцуулж харахад 2008 оны 3 дугаар улиралд нөөц сан 62.6 хувийг эзэлж байсан бол 2009 оны 3 дугаар улиралд 59.7 хувь болж улмаар 2010 оны 3 дугаар улиралд 58.3 хувь болж буурсан байна. Тайлант үеийн нийт эзэмшигчийн өмч 36.4 хувь болсон нь өмнөх оны мөн үеийнхээс 3.2 пунктээр өссөн бөгөөд өр төлбөр нь 1.8 пунктээр өмнөх оноос буурсан байна.

График-3.




Хүснэгт-5

2010 оны 03-р улирлын тайлант үеийн цэвэр ашиг алдагдлыг компаниудаар харуулбал:

Компанийн нэр	Цэвэр ашиг алдагдал /сая төгрөг/	Эзлэх хувь
Монгол даатгал	922.4	26.2
Бодь даатгал	152.4	4.3
Миг даатгал	225.0	6.4
Тэнгэр даатгал /Прайм/	239.6	6.8
Ард даатгал	155.4	4.4
Номин даатгал	367.4	10.4
Түшиг даатгал	190.8	5.4
Практикал даатгал	597.5	17.0
Улаанбаатар хотын даатгал	33.3	0.9
УБ даатгал	86.9	2.5
Монгол траст Холдинг даатгал	54.9	1.6
Ган зам даатгал	318.2	9.0
Жонон даатгал	124.8	3.5
Мөнх даатгал	50.3	1.4
Гранд даатгал	3.8	0.1
ЕРДИЙН ДААТГАЛЫН НИЙТ ДҮН	3 522.7	100.0
Нэйшнл лайф даатгал	(88.9)	0,0
СИСТЕМИЙН НИЙТ ДҮН	3 433,80	

График-4



2010 оны 3 дугаар улирлын байдлаар ердийн даатгалын 15 компани бүгд цэвэр ашигтай ажилласан бөгөөд цэвэр ашгийн 26.2 хувийг Монгол даатгал эзэлж 922.4 сая төгрөгийн ашигтай ажилласан, Практикал даатгал 17.0 хувь буюу 597.5 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь нийт салбарын цэвэр ашгийн 43.2 хувийг эзэлсэн байна.

Урт хугацаат даатгалын компани болох “Нэйшнл лайф даатгал” ХХК 88.9 саяын алдагдалтай ажиллаж системийн нийт цэвэр ашгийг бууруулахад нөлөөлж байна.

Даатгалын компаниудын нөөц сангийн талаар.

2009 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 232 дугаар тогтоолоор батлагдсан “Ердийн даатгалын нөөц сан бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”, 2009 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 276 дугаар тогтоолоор батлагдсан “ Урт хугацааны даатгалын нөөц санг бүрдүүлэх, зарцуулах түүнд хяналт тавих журам”-ын дагуу энэ оны 1 дүгээр улирлаас эхлэн ердийн даатгалын компаниуд орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн сан, учирсан боловч нэхэмжлээгүй нөөцийн сан, нэхэмжилсэн хохирлын нөөцийн сан, учирч болзошгүй хохирлын нөөцийн сан, тусгайлсан нөөц сан гэсэн сангуудыг, урт хугацааны даатгалын компани нь хувь оролцоотой гэрээний нөөц сан, хувь оролцоогүй гэрээний нөөц сан, хөрөнгө оруулалттай холбоотой гэрээний нөөц сангуудыг байгуулж эхэлсэн. Тайлант хугацаанд ердийн даатгалын нийт 26777.4 сая төгрөгийн, урт хугацааны даатгалын 69.2 сая төгрөгийн даатгалын нөөц сантай ажилласан байна.

/Хавсралт№01,02-т/

IV. ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ОРЛОГО

Даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулсан даатгагчид 2010 оны 3 дугаар улиралд нийт 23112.2 сая төгрөгийн орлоготой ажилласан байна. Үүний төгрөг буюу 99.3 хувийг ердийн даатгал, 160.5 сая төгрөг буюу 0.7 хувийг урт хугацааны даатгалын хураамжийн орлого бүрдүүлж байна.

Ердийн даатгалын хувьд даатгалын нийт үнэлгээ нь 8.5 их наяд төгрөг болсон байна.

Ердийн даатгалын компаниуд даатгалын нийт хураамжийн орлогын 6359.4 сая төгрөг буюу 27.7 хувийг давхар даатгалд, 97.5 сая төгрөг буюу 0.4 хувийг буцаасан даатгалын хураамжид төлж 16494.8 сая төгрөгийн даатгалын цэвэр хураамжийн орлоготой ажилласан байна.

2010 оны 3 дугаар улирлын даатгалын нийт хураамжийн орлогын 13043.3 сая төгрөг буюу 56.8 хувь даатгалын төлөөлөгчөөр, 0.9 хувь буюу 217.6 сая төгрөгийг даатгалын зуучлагчаар дамжуулан олсон байна.

2010 оны 3 дугаар улиралд нийт 22951.7 сая төгрөгийн ердийн даатгалын хураамжийн орлого олсны 22.6 хувь буюу 5190.7 сая төгрөг нь хөрөнгийн даатгалын, 22.7 хувь буюу 5207.2 сая төгрөг нь авто тээврийн хэрэгслийн даатгалын, 9.0 хувь буюу 2062.7 сая төгрөг нь агаарын хөлгийн даатгалын, 13.7 хувь буюу 3144.9 сая төгрөг нь хариуцлагын даатгалын, 12.3 хувь буюу 2822.4 сая төгрөг нь гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгалын, 7.7 хувь буюу 1761.1 сая төгрөг нь авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгалын, 4.3 хувь буюу 977.6 сая төгрөг нь санхүүгийн даатгалын, 2.1 хувь буюу 489.0 сая төгрөг нь ачааны даатгалын, 5.6 хувь буюу 1294.5 сая барилга угсралтын даатгалын, газар тариалангийн даатгалын, мал амьтдын даатгалын хураамжаас орсон орлого тус тус бүрдүүлсэн байна.

/Хүснэгт-7/

Ердийн даатгалын хураамжийн орлого

(сая төгрөгөөр)

№	Даатгалын ангилал	2009-III	2010-III	Өсөлт /бууралт/
1	Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал (2009 онд амь нас, ашиг сонирхол, эрүүл мэндийн даатгал)	1867.0	2822.4	955.4
2	Хөрөнгийн даатгал	4756.1	5190.7	434.6
3	Автотээврийн хэрэгслийн даатгал	3835.8	5207.2	1371.4
4	Ачааны даатгал	327.8	489.0	161.2
5	Газар тариалангийн даатгал	1.3	0	-1.3
6	Мал амьтдын даатгал	11.1	1.6	-9.5
7	Агаарын хөлгийн даатгал	2705.4	2062.7	-642.7
8	Барилга угсралтын даатгал	354.9	1294.5	939.6
9	Автотээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	1600.0	1761.1	161.1
10	Хариуцлагын даатгал	1470.1	3144.9	1674.8
11	Санхүүгийн даатгал	530.3	977.6	447.3
	Дүн	17459.8	22951.7	5491.8

2010 оны 3 дугаар улирлын даатгалын хураамжийн орлогын хэмжээг 2009 оны мөн үеийнхтэй харьцуулахад 5.5 тэрбум төгрөгөөр буюу 1.3 дахин өссөн дүнтэй гарсан байна 2010 оны 03-р улирлын хураамжийн орлогыг графикт харуулбал: *График-6*




Даатгалын компаниудыг 2010 оны 3 дугаар улиралд олсон даатгалын нийт хураамжийн орлогоор жагсаахад нийт хураамжийн орлогын 28.8 хувь буюу 6646.6 сая төгрөгийг “Монгол даатгал” ХХК бүрдүүлж тэргүүлсэн бол “Бодь даатгал” ХХК нийт хураамжийн орлогын 20.0 хувь буюу 4611.9 сая төгрөгийг, “Тэнгэр даатгал” ХХК нийт хураамжийн орлогын 13.7 хувь буюу 3163.4 сая төгрөгийг бүрдүүлснээр нийт зах зээлийн 62.5 хувийг эдгээр компаниудын даатгалын хураамжийн орлого эзэлсэн байна.

(Хүснэгт-6).

№	Даатгалын компаниудын нэрс	Хураамжийн орлого	Эзлэх хувь
1	Монгол даатгал	6 646.6	28.8
2	Бодь даатгал	4 611.9	20.0
3	МИГ даатгал	2 497.0	10.8
4	Тэнгэр даатгал /Прайм/	3 163.4	13.7
5	Номин даатгал	1 502.4	6.5
6	Ард даатгал	1 402.3	6.1
7	Практикал даатгал	888.1	3.8
8	Түшиг даатгал	572.8	2.5
9	Улаанбаатар хотын даатгал	83.8	0.4
10	Мөнх даатгал	385.8	1.7
11	Жонон даатгал	61.3	0.3
12	УБ даатгал	141.3	0.6
13	Монгол траст Холдинг даатгал	4.8	0.0
14	Гранд даатгал	382.0	1.7
15	Нэйшнл лайф даатгал	160.5	0.7
16	Ган зам даатгал	608.2	2.6
ДҮН		23 112.2	100.0

График-5



Урт хугацааны даатгалын нийт орлого 160.5 сая төгрөг байгаагаас хугацаат амьдралын даатгал 129.2 сая төгрөг, хуримтлалын даатгал 0.3 сая төгрөг, эрүүл мэндийн даатгал 31.0 сая төгрөг байна. Урт хугацааны даатгалын хураамжийн орлогын 25.2 хувийг хувь хүний даатгал, 74.8 хувийг группын даатгал эзэлж байна.

Нийт хураамжийн орлогын 17.0 хувийг даатгалын зуучлагчаар, 83.0 хувийг даатгалын төлөөлөгчөөр дамжуулан олсон байна.

Ү. ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨРИЙН ТАЛААР.

2010 оны 3 дугаар улиралд нийт 4789.2 сая төгрөгийн даатгалын нөхөн төлбөрийг иргэд, даатгуулагчдад олгосноос 4758.9 сая төгрөгийн даатгалын нөхөн төлбөрийг ердийн даатгалаар, 30.3 сая төгрөгийг урт хугацааны даатгалаар тус тус олгосон байна.

Ердийн даатгалын нөхөн төлбөрийн 18.5 хувь буюу 880.0 сая төгрөг нь хөрөнгийн даатгалын, 46.5 хувь буюу 2212.1 сая төгрөг нь авто тээврийн хэрэгслийн даатгалын, 0 хувь буюу 1.7 сая төгрөг нь агаарын хөлгийн даатгалын, 3.4 хувь буюу 159.6 сая төгрөг нь хариуцлагын даатгалын, 10.8 хувь буюу 514.8 сая төгрөг нь гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгалын, 11.7 хувь буюу 557.4 сая төгрөг нь авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгалын, 6.4 хувь буюу 305.2 сая төгрөг нь санхүүгийн даатгалын, 0.2 хувь буюу 9.6 сая төгрөг мал амьтадын даатгал, 1.9 хувь буюу 89.0 сая төгрөг барилга угсралтын даатгалын, 0.6 хувь буюу 29.5 сая төгрөг ачааны даатгалын нөхөн төлбөрт тус тус олгогдсон байна

График-7

2010 оны 03-р улирлын байдлаар



2010 оны 3 дугаар улиралд даатгуулагчдад олгосон даатгалын нөхөн төлбөрийн хэмжээг 2009 оны мөн үеийнхтэй харьцуулахад 999.8 сая төгрөгөөр буюу 1.3 дахин өссөн дүнтэй гарсан байна.

Хүснэгт-9

Даатгалын нөхөн төлбөрийн хэмжээ

(сая төг)

	Даатгалын хэлбэрээр	2009-III	2010-III	Өсөлт бууралт
1	Газар тариалангийн	0.0	0.0	0.0
2	Мал амьтдын	2.0	9.6	7.6
3	Агаарын хөлгийн	8.7	1.7	-7.0
4	Барилга угсралтын	12.3	89.0	76.7
5	Хариуцлагын	57.9	159.6	101.7
6	Ачааны	80.7	29.5	-51.2
7	Санхүүгийн	248.9	305.2	56.3
8	Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын	398.4	557.4	159.0
9	Гэнэтийн осол, эмчилгээний зардлын	451.3	514.8	63.5
10	Хөрөнгийн	551.7	880.0	328.3
11	Авто тээврийн хэрэгслийн	1 947.2	2 212.1	264.9
		3 759.1	4 758.9	999.8

Урт хугацааны даатгалаар 30.3 сая төгрөгийн нөхөн төлбөр олгосоноос 12.1 сая төгрөгийг хугацаат амьдралын даатгалаар, 18.3 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалаар тус тус нийт 139 хувь хүнд нөхөн төлбөр олгосон байна. Нийт нөхөн төлбөрийн 20.8 сая төгрөгийг давхар даатгагчаас төлүүлсэн байна.

VI. ХОХИРОЛ НӨХӨЛТИЙН ТҮВШИН

2010 оны 3 дугаар улиралд даатгалын хохирол нөхөлтийн түвшин даатгалын салбарын дүнгээр 33.5 хувь болж 2009 оны мөн үеийнхээс 3.6 пунктээр өссөн ба энэ нь даатгалын нөхөн төлбөр олголт нэмэгдэж байгааг болон компаниудын нөхөн төлбөрийн чадавхи нэмэгдсэнийг харуулж байна.

График-8



Даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй компаниудыг даатгалын хохирол нөхөлтийн түвшингээр харьцуулахад 2010 оны 3 дугаар улирлын байдлаар “Монгол даатгал” ХХК хамгийн өндөр буюу 47.2 хувьтай байгаа бол “Гранд даатгал” ХХК, Монгол траст холдинг даатгал ХХК-иуд хамгийн бага буюу 1.4 хувьтай байна.

Даатгалын компаниудын нөөц сангийн талаар.

2010 оны 1-р улирлаас эхлэн даатгалын компаниуд нөөц сангаа орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн сан, учирсан боловч нэхэмжлээгүй нөөцийн сан, нэхэмжилсэн хохирлын нөөцийн сан, учирч болзошгүй хохирлын нөөцийн сан, тусгайлсан нөөц сан гэсэн сангуудыг байгуулж эхэлсэн бөгөөд энэ нь оны эхнээс тайлант оны 3-р улирал хүртэлх өөрчлөлтийг ердийн даатгалын компаниудын нөөц санг /Хавсралт №01/, урт хугацаат даатгалын компанийн нөөц санг /Хавсралт №02/ харуулсан.

(Хүснэгт-9).

№	Даатгалын компанийн нэр	2009 он	2010 он	Өөрчлөлт /пунктээр/
1	Ард даатгал ХХК	39.9	39.7	-0.2
2	Бодь даатгал ХХК	25.8	25.3	-0.5
3	Ган зам даатгал ХХК	1.8	9.6	7.8
4	Гранд даатгал ХХК	-	1.4	-
5	Жонон даатгал ХХК	-	19.8	-
6	Миг даатгал ХХК	26.5	24.9	-1.6
7	Монгол даатгал ХХК	31.9	47.2	15.3
8	Монгол траст холдинг даатгал ХХК	2.8	1.4	-1.4
9	Мөнх даатгал ХХК	31.8	19.1	-12.7

10	Номин даатгал ХХК	11.0	36.1	25.1
11	Тэнгэр даатгал ХХК /Прайм/	32.6	42.6	10.0
12	Практикал даатгал ХХК	31.5	19.7	-11.8
13	Түшиг даатгал ХХК	48.7	17.6	-31.1
14	УБ даатгал ХХК	20.2	16.6	-3.6
15	Улаанбаатар хотын даатгал ХХК	28.0	33.5	5.5
16	Нэйшнл лайф даатгал	17.1	27.6	10.5
	ДҮН	29.9	33.5	3.6

Даатгалын компаниудаас 2010 оны 3 дугаар улиралд даатгуулагчдад олгосон даатгалын хохирол нөхөлтийн түвшинг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад “Монгол даатгал” ХХК 15.3 пунктээр, “Номин даатгал” ХХК 25.1 пунктээр, “Нэйшнл лайф даатгал” 10.5 пунктээр, “Тэнгэр даатгал” ХХК 10.0 пунктээр, “УБ хотын даатгал” ХХК 5.5 пунктээр, “Ган зам даатгал” ХХК 7.8 пунктээр тус тус өссөн бол “Ард даатгал” ХХК 0.2 пунктээр, “Мөнх даатгал” ХХК 12.7 пунктээр, “Түшиг даатгал” ХХК, 31.1 пунктээр “Миг даатгал” ХХК 1.6 пунктээр, “Бодь даатгал” ХХК 0.5 пунктээр, “УБ даатгал 3.6 пунктээр, “Практикал даатгал” ХХК 11.8 пунктээр, “Монгол траст холдинг даатгал” ХХК 1.4 пунктээр тус тус буурсан байна.

VII. ДАВХАР ДААТГАЛ

2010 оны 3 дугаар улиралд ердийн даатгалын үйл ажиллагаа явуулж буй 9 компани гадаадын давхар даатгалын компаниудад их хэмжээний даатгалын эрсдэлээ давхар даатгуулж 6410.1 сая төгрөгийн хураамж төлсөн нь өнгөрөгч оны мөн үетэй харьцуулахад 1789.0 сая төгрөгөөр буюу 1.4 дахин өссөн дүнтэй гарлаа.

Хүснэгт-10

Давхар даатгалын хураамж (сая төгрөгөөр)

№	Компанийн нэр	2009-III		2010-III		Өсөлт/бууралт		
		тоо	хувь	тоо	хувь	тоо	пункт	
1	Ард даатгал	135.9	2.9	256.3	4	120.4	1.1	
2	Бодь даатгал	1096.5	23.7	2738.4	42.7	1641.9	19	
3	Тэнгэр даатгал	271.5	5.9	1183.2	18.5	911.7	12.6	
4	Практикал даатгал	104.2	2.3	106.3	1.7	2.1	-0.6	
5	Миг даатгал	2509.2	54.3	673.5	10.5	-	1835.7	-43.8
6	Монгол даатгал	443.3	9.6	1095.4	17	652.1	7.4	
7	Номин даатгал	54.5	1.2	123.3	1.9	68.8	0.7	
8	Гранд даатгал			183	2.9	183	2.9	
9	Нэйшнл лайф даатгал	5.9	0.1	50.7	0.8	44.8	0.7	
	ДҮН	4621.1	100	6410.1	100	1789	0	

2010 оны мөн үеийнхтэй харьцуулахад “Ард даатгал” ХХК 120.4 сая, “Бодь даатгал” ХХК 1641.9 сая, “Тэнгэр даатгал” ХХК 911.7 сая, “Практикал даатгал” ХХК 2.1 сая, “Монгол

даатгал” ХХК 652.1 сая, “Номин даатгал” ХХК 68.8 сая, “Нэйшнл лайф даатгал” ХХК 44.8 сая төгрөгөөр тус тус өсч, “Миг даатгал” ХХК 1835.7 сая төгрөгөөр буурсан байна.

VIII. ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧ

Тайлант оны 1 дүгээр улирлын байдлаар нийтдээ 5 компаниас даатгалын зуучлагчийн орлого 18.7 сая төгрөг, бусад орлого 0.5 сая төгрөг нийт 19.2 сая төгрөгийн орлого олсон байна.

2010 оны 3 дугаар улирлын байдлаар санхүүгийн тайлангаа 8 компани ирүүлсэн байгаа бөгөөд үүнээс “Жомолхари” ХХК нь үндсэн үйл ажиллагааны орлого олоогүй бөгөөд бусад 7 зуучлагч компани нийт 141.2 сая төгрөгийн орлого олсоноос 129.2 сая төгрөг даатгалын зуучлагч компанийн орлого 12.0 сая төгрөг нь бусад орлогыг төвлөрүүлсэн байна.

IX. ДААТГАЛЫН ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧ

2010 оны 1-р улиралд даатгалын хохирол үнэлэгч 2 компани нь 1.6 сая төгрөгийн орлоготой ажилласан бөгөөд нийт 68.6 сая төгрөгийн даатгалын хохирол үнэлсэн байна.

Энэ оны 3-р улиралд нийт 4 компани нь өссөн дүнгээр нийт 91.0 сая төгрөгийн орлого олсоноос даатгалын хохирол үнэлгээний орлого 27.9 сая төгрөг, бусад орлого 63.1 сая төгрөгийн борлуулалттай ажиллажээ.

X. ДҮГНЭЛТ

Даатгалын байгууллагуудын санхүүгийн мэдээллээс харахад даатгалын зах зээл дээрх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тоо өмнөх оны тайлант үеийнхээс 1.2 дахин нэмэгдэж даатгалын хохирол үнэлэгч, даатгалын зуучлагч шинээр өсөн нэмэгдэж байгаа нь энэ зах зээлийн цар хүрээний өсөлтийн хурдацыг илтгэж байна.

Даатгалын зах зээл дээр 2010 оны 3 дугаар улиралд үйл ажиллагаа явуулсан даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид нийт 23344.4 сая төгрөгийн орлого олсон байна. Энэхүү орлогын 22951.7 сая төгрөг буюу 98.3 хувийг ердийн даатгалын компаниуд, 160.5 сая төгрөг буюу 0.7 хувийг урт хугацааны даатгалын компани, 141.2 сая төгрөг буюу 0.6 хувийг даатгалын зуучлагч компаниуд, 91.0 сая төгрөг буюу 0.4 хувийг даатгалын хохирол үнэлэгч компаниудын олсон орлого тус тус бүрдүүлсэн болно.

Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчийн олсон нийт орлогын 99 хувь буюу 23112.2 сая төгрөг нь даатгалын нийт хураамжийн орлого, үлдэх хэсэг нь бусад орлого болон даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгч компаниудын олсон орлого байна.

Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчийн нийт хөрөнгийн хэмжээ өмнөх онуудын мөн үеийнхтэй харьцуулахад даруй 1.2 дахин өсч 46.0 тэрбум төгрөгт хүрч, тайлант үеийн цэвэр ашиг 3.4 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 0.9 тэрбумаар өссөн нь даатгалын байгууллагуудын санхүүгийн чадавхи нэмэгдэж байгааг харуулахаас гадна салбарын хэмжээнд ашигтай ажиллаж байгаа нь аливаа эрсдэлийг даван туулах хандлага, чадвар нэмэгдэж байна гэж дүгнэхээр байна.

ДААТГАЛЫН ГАЗАР

**Ердийн даатгалын компанийн нөөц сангуудын
үлдэгдэл**

		Хавсралтаар №01/ Сая төгрөг					
Улирал		10.09.30					
№	Компанийн нэр	Орлогд тооцоогүй хураамжийн нөөцийн сан	Учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц сан	Нэхэмжилсэн хохирлын нөөц сан	Учирч болзошгүй хохирлын нөөц сан	Тусгайлсан нөөц сан	Нийт дүн
1	Ард даатгал ХХК	779.5	187.4	51.9	217.1	461.3	1697.2
2	Бодь даатгал ХХК	1146.1	477.2		275.3	751.1	2649.7
3	Ган зам даатгал ХХК	368.4	87.4	0	71.1	122.7	649.6
4	Гранд даатгал ХХК	123.4					123.4
5	Жонон даатгал ХХК	37.7	43.2		26.2	55.6	162.7
6	Миг даатгал ХХК	1236.3	453.8		181.9	499.6	2371.6
7	Монгол даатгал ХХК	3542.2	1836.5		1688.9	4222.3	11289.9
8	Монгол траст холдинг даатгал ХХК	3.0			315.7		318.7
9	Мөнх даатгал ХХК	273.2	103.8		41.3	103.2	521.5
10	Номин даатгал ХХК	807.9	207.7		95.1	253.7	1364.4
11	Тэнгэр даатгал ХХК /Прайм/	1252.0	502.1		110.3	582.7	2447.1
12	Практикал даатгал ХХК	656.1	103.1		57.1	165.2	981.5
13	Түшиг даатгал ХХК	385.9	232.8		117.1	417.1	1152.9
14	УБ даатгал ХХК	95.0	129.2		78.9	197.3	500.4
15	Улаанбаатар хотын даатгал ХХК	48.0	144.1		114.5	240.2	546.8
	ДҮН	10754.7	4508.3	51.9	3390.5	8072.0	26777.4

УРТ ХУГАЦААТ ДААТГАЛЫН КОМПАНИЙН НӨӨЦ САНГИЙН ТАЙЛАН

Хавсралтаар №02/ Сая төгрөг

№	Компанийн нэр	10.01.01			10.09.30			Өөрчлөлт +-		
		Хувь оролцоотой гэрээний нөөц сан	Хувь оролцоогүй гэрээний нөөц сан	Хөрөнгө оруулалттай холбоотой гэрээний нөөц сан	Хувь оролцоотой гэрээний нөөц сан	Хувь оролцоогүй гэрээний нөөц сан	Хөрөнгө оруулалттай холбоотой гэрээний нөөц сан	Хувь оролцоотой гэрээний нөөц сан	Хувь оролцоогүй гэрээний нөөц сан	Хөрөнгө оруулалттай холбоотой гэрээний нөөц сан
1	Нэйшнл лайф даатгал ХХК		44.3			69.2			24.9	